

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Цэрмаа	Дугаар	L207
Оршин суугаа аймаг	Увс аймаг	Оршин суугаа сум	Зүүнхангай сум
Төрсөн газар	Зүүнхангай сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Бишрэлт гэгээний тухай	Сүм хийдийн дугаар	УВЗХ 019
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 14	Ярилцлага авсан хүн	С.Билэг-Өрнөх

Увс аймгийн Зүүнхангай сумын Бишрэлт гэгээний тухай

Билэг-Өрнөх: Увс аймгийн Зүүнхангай сумын өндөр настан Цэрмаа гуйтай уулзаж байна аа.

Цэрмаа: Гэнгээгийн аав, Бадамсамбуугийн буурал аав.Тэгэхээр чинь тэр буурал, ганц самган байна ш дээ.Тэр чинь тэр хоёр эрэгтэй ламын эгч нь ш дээ, төрсөн эгч нь.Бадамсамбуугийн ганц авга эгч нь.Тэгэхээр манай ээжтэй төрсөн ах дүү хоёрын хүүхэд байхгүй юу.

Билэг-Өрнөх: Ах дүү гурвуулаа юм байна ш дээ?

Цэрмаа: Гурвуулаа охинтойгоо. За тэгээд солонго татахлээр Тэсийн хувилгаан хүн байжээ, багш. Өглөө босоод тэр хувилгаан хүн ингэж хэлж гэнэ ээ. Өө энэ Гэмбэлийнд өнөөдөр нэг сайн хүн төрлөө дөө. Над руу одоо нэг алд шар хадаг бариад нэг хүн ирэх гэж байна гэж хэлжээ.

Билэг-Өрнөх: Хэнийд гэнэ ээ?

Цэрмаа: Тэсд нэг лам байжээ. / хажуунаас нь охин нь боллоотой нэгэн тэр аавынх нь нэрийг хэн гэнэ ээ гэж дамжуултал/ Гэмбэл гэдэг байх аа, буруу юм хэлчих вий дээ. Гэмбэл л гэх шиг болно лээ, тэрний аавын нэрийг л мартчих шиг боллоо , за яахав. Тэгээд л өглөө босоод цай ууж байгаад Гэмбэлийнд нэг сайн хүүхэд төрж байна аа, алд шар хадаг аваад одоохон над дээр ирэх нь ээ гэж хэлж, солонго татаад. Тэгээд очихлээр нь ингэж хэлж л дээ, тэр ламд өглөө эрт очихгүй юу. Энэ хүн ингээд гарлаа, солонго энэ тэр татлаа гээд, тэр хувилгааныг бид нар лам ах гэж авгайлдаг юм. Тэгээд очжээ. Тэгээд очихлээр нь за дошгин газар төрж, оргиу гэж мөн ч мундаг газар төрж. Өндөр ч газар юм, улаан ямаа сэтэрлэж тавиарай, тавиад тэр хадан дээр гаргачих гэж.Тэгээд нэг улаан ямаа сэтэрлээд ууланд гаргачихаж.Тавьчихаж, тэгээд одоо тийм газар, ер нь дошгин газар төрсөн гэж байгаа юм даа. Уул газар нь оргиу гэж сайхан нэртэй юм байна лээ. Тэгээд энэ амьтан тэрэн дээр буугаад л байх юм.

Билэг-Өрнөх: Бишрэлт хувилгааны тухай?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Цэрмаа: Тэр хувилгааны тухай би нэрээр нь хэлж чадахгүй шүү. Нэрийг мэднэ, мэдэх юм уг нь. Нэрийг нь хэлэхгүй байна, бие. Тэр Бишрэлт хувилгааны юмнуудаас хамгийн ойрхон гэж байгаа нь, би тэр хүүхдүүд нь авга эгчид нь заримд нь туниад л , заримд нь...Ороод ирсэн чинь энэ Аюушийнх шиг дээлтэй, том том дугуйтай хээтэй торгон дээлтэй тийм хүн байлаа, тэр лам. Тэгээд л нэг ингээд л тэр ном уншиж байгаа юм байлгүй.Тэгээд нэг тийм халзан...

Билэг-Өрнөх: Том хүн байсан уу, биеэр ямархуу хүн байсан?

Цэрмаа: Өө том, биеэр нэг сайхан тийм бөөрөнхий бөмбийсэн толгойтой, үсээ ингээд авчихсан. Жаахан байхад хүн чинь, би тэгэхэд нэг 4, 3 настай л байсан. За тийм хүн, тэгээд энэ одоо наашаа хүрээд ир чи гээд надад нэг адис өгдөг юм аа, өнөө хүн чинь зайлуул хүн сээд байх юу байхав дээ, лам.Ээ бурхан тэнгэр минь, адис өглөө. Тэгээд эгч нь , том өөрийн нь төрсөн эгч нь байгүй юу. Тэр ер нь их мэргэн яндаг хүн байж дээ, хувилгаан.Наашаа хүрээд ир гэж, чи ондоо мундаг авгай язгуур, мундаг хүн байжээ.Тэр авгай, тэр ганц охин, хоёр дүү төрүүлсэн сайн дүү төрүүлсэн, нэг ахдаа.Тэгээд наашаа ирэхлээр нь авгай гэж ийм үстэй авгай байдаг мэдэх үү, та нар. Тийм авгай, цацаг шүр мөнгөнд даагдахгүй тийм авгай байж, миний буурал ээж.Тэгээд одоо чи за хэзээ гэнэ ээ, авгайгийнхаа хэрэглэлийг авч далд хий.Одоо чи болохгүй энийг гэж ингэжээ.Тэгээд одоо яагаад байгаа юм бол энэ лам яачихсан юм бол гээд нэрээр хэлэхгүй юу даа, нөгөө эгч нь дагуулаад гарсан эгч нь юм болохлээр. Зүгээр зүгээр гээд. Тэгээд тэр нэг хүүхэн хоёр авгайгийг нь яривал барахгүй ээ , тэрүүгээр яахав. Үгүй ээ, яахав ч биш л дээ, уг нь тэр орох л ёстой юм байна лээ л дээ. Тэгээд нөгөө лам чинь ингэдэг байжээ. За та одоо ингээд энэ хэрэглэл энэ тэрээ тавьчих, нөгөө мөнгөн хэрэглэл энэ тэрээ. Манай ээж мээж манай нагац энэ тэр надад ярьдаг байлаа.Түүнээс би өөрөө тэрийг тэгж мэдэхгүй ш дээ. За ингээд ярьж байлаа.Тэгсэн чинь үгүй одоо намайг ингэдэг гэсэн. Нас наслуулах гэсэн байна аа. Сүүлийн үед бас хувиралт ордог юм байна л даа, юманд чинь. Тэр дураараа, тэр баян хүний ганц хүү байж байгаад л тэр хэрэглэл энэ тэрийг чинь солих учиртай. Өндөр нас насалсан л даа, манай буурал ээж. Тэгээд солльдог юм байна. Тэгээд хотгойдоос нэг авгай авч өгөх гэдэг юм байна, манай буурал аавд. Нөгөө авгайн хэрэглэл өгсөн хүнд авгай авч өгнө. Авгай авч өгнө гэсэн гэнэ ээ, ламд биш шүү дээ. Одоо тэр манай хөгшин буурал ээж байна ш дээ, тэр авгайнхаа хэрэглэлийг өгчихсөн авгай биш боллоо ш дээ. Тэрүүнд л авгай авч өгөхгүй юу.

Билэг-Өрнөх: Эмэгтэй хүнд...?

Цэрмаа: Эгчийнхээ нөхөрт, авгайн хэрэглэлийг нь өгөөд л. Тэр мэргэнийхээ юүнд л тийм юм бүүсан байна л даа. Эгчийнхээ нөхөрт, хүргэн ах нь л байхгүй юу даа. Тэгээд тэрүүнд авгай авна, эндээс авна гээд. Нэг айл байсан, ядуу шиг айл байсан юм байна гэнэ лээ л дээ, түүхэндээ. Тэгээд тэрнийг аваад өгчихжээ.Сайхан хүүхэн бараг манай ээжийн үеийн юм байна лээ л дээ. Тийм юм авч өгч гэнэ, ганц хархүүтэй,гурван охин төрүүлж өгсөн. Тэгээд ганц хархүүдээ хань хийх авгай авна аа гэдэг юм байна.Тэгээд жаахан шинэ гэр барьжээ. Тэгээд тэрүүндээ айлын авгай авч өгдөг юм байна.Ганц хархүүдээ хань хийнэ ээ гээд, тэгээд тэрнээс чинь хоёр гурваараа 9 хүүхэд гарсан байх аа. Тэгээд ес дөрөв хоёр чинь хэд билээ, тэгээд хоёр авгайтайгаа энээ тэрээ болж сайхан амьдарч байгаад тэгээд манай буурал аав нас барсан. Манай буурлууд тэгээд л өндөрлөсөн. За

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

тэр хувилгаан бол их мэргэн хүн байжээ. Нэг хэсэг одоо энэ хувилгааны талын тасархай их сайн явна аа, ер нь их сайн явна гэж хэлж байсан байх юм байна. Хүн, ангийн хүн тэрийг бүр явчихсан хойно.Тэгээд нэг хэсэгтээ ч ёстой сайхан л байсан, сайн л байсан. Тэгээд одоо яахав сайн сайхан байх нь байж л байна, бас. Үгүй ээ яахав сайхан л байна. Тэгээд аймаг аваад явсан.

Билэг-Өрнөх: Хэдэн онд аваад явсан юм?

Цэрмаа: Мэдэхгүй оныг нь мартчихаж.Тэр эсэргүүний үед чинь л байхгүй юу, яг тэрийг л хэлмэгдүүлээд л .Тэгээд л аваад явчихсан юм, тэгээд аваад яваад шоронд хийжээ, нөгөө ламыг . Бүгдийг нь хийхгүй юу даа.

Билэг-Өрнөх: Улаангомд очоод уу?

Цэрмаа: Тийм, Улаангомд. Тэгэхлээр Улаангомд очоод за та нар ийм л байдаг байж намайг гаргаадах та нар, би нэг гарч ертөнцийн эргэн тойрон харна, хармаар байна. Тэгээд буцаагаад хийчих ингэж хэлжээ, өнөө лам. Тэгэхлээр нь зэрэг гаргаад өнөө улс чинь гаргачихсан чинь гадаа гарж хэдэн зүг рүү харж ингэж залбирч байснаа хойшоогоо ингээд л нам болсон гэж хэлдэг юм байна лээ, би үзээгүй.Тэгэхдээ ортой, манайхны өвөг эцэг янз бүрийн тэр ээж аав нар бүгд ярьж байсан. Тэгээд таалал болжээ. Тэгээд тэр таалал болохлээр нь юун дээр л тавьсан юм байна лээ л дээ, тэр чинь ачигдаж яваа ч үгүй.Ямар юм билээ, Улаангомын. Тэгээд л таалал болсон юм. Тэр ч явдалтай хүн л дээ, зайлуул.